



Иргэдийн мэдээлэл авах эрхийг нэмэгдүүлж, монголд ил тод байдал, шударга ёсыг хөхиүлэн дэмжих нь төсөл

СУДАЛГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

Монгол Улсын Үндсэн хуульд Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. хэмээн заасан байдаг.

Төслийн хүрээнд иргэдийн мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх тухай мэдлэг, ойлголт, төрийн байгууллагын ил тод, шударга байдлын түвшин, мэдээлэл түгээх суваг, боломжийг тодорхойлж, иргэдэд хэрэгтэй мэдээллийн санал авах, сумын төрийн байгууллага, төрийн албан хаагч, үйлчилгээний өнөөгийн байдлыг тодорхойлж, төслийн цаашдын үйл ажиллагаанд хэрэгцээтэй мэдээлэл бүрдүүлэхээс гадна төслийн эцсийн үр дүнг үнэлэхийн тулд суурь болон төгсгөлийн судалгааг хийлээ.


Төслийн хүрээнд сум бүрт байгуулагдсан мониторингийн багийн тусламжтайгаар 2015 оны 2-р сарын 18-ны өдрөөс 5-р сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд судалгааны мэдээллийг цуглуулж, нэгтгэн боловсруулав. Төгсгөлийн судалгаанд 8 аймаг, 20 сумын 1712 иргэн хамрагдсан.

СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮНГЭЭС:

- *Иргэдийн мэдээлэл авах эрхийн тухай хуулийн мэдлэг, ойлголт сайжирсан байна.*


Төгсгөлийн судалгаанд оролцсон иргэдийн 98% нь “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-тай холбоотой мэдээлэл авсан байна. Үүнээс 37% нь Төрийн болон төсвийн байгууллагын албан хаагчид байна.

Төрийн албан хаагчийн мэдээлэл авах эрхийн тухай хуулийг уншиж, сонсож, үзэж байсан суваг



Суурь судалгаагаар иргэдийн 62% нь мэдээлэл авах эрхтэй гэдгээ, 9 хувь нь мэдээлэл авах эрхийн тухай хуулиа “Маш сайн”, “Сайн” мэднэ гэж хариулж байсан бол төгсгөлийн судалгаагаар мэдээлэл авах эрхийн тухай ойлголт 17%-иар, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн ойлголт 12%-иар тус тус нэмэгджээ. Хуулийн мэдлэг шалгасан асуултад буруу хариулах байдал 4-9 хувиар буурсан байна.

Хуулиар хориглосон мэдээллийг авах эрхтэй гэж хариулсан байдал



- *Мэдээлэл нээлттэй, ил тод болж төрийн байгууллагын үйлчилгээ сайжирсан хүндрэл чирэгдэлгүй болжээ.*

Төрийн байгууллагын мэдээлэл нээлттэй, ил тод байдал, албан тушаалтны ажлаа тайлагнах байдал хангалтгүйгээс иргэд хангалттай мэдээлэл авч чаддаггүй, улмаар иргэн, төрийн албан хаагчдын дунд үл ойлголцох байдал үүсдэг байсан. Мөн албан хаагчид ажлын байран дээрээ байдаггүй нь төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд хүндрэл чирэгдэл үүсгэж, төрийн байгууллага, ТАХ-ын нэр хүнд унагах нэгэн шалтгаан болж байсан юм.

Суурь судалгааны дүнд “Мэдээлэл авах эрхийн тухай хуулиар ил тод байна хэмээн заасан 4 төрлийн мэдээллийг мэдээллийн самбар болон вэб сайтад хүний нүдэнд шууд харагдахуйц байдлаар байршуулан хуульд заасан хугацаанд нь тогтмол шинэчлэх”. гэсэн зөвлөмж хүргүүлсэн. Сумын удирдлага зөвлөмжийг хүлээн авснаар мэдээллийн самбарын мэдээлэл дунджаар 10 хувиар, мэдээлэл шинэчлэгдэх байдал 18 хувиар өссөн байна.

- *Төслийн хүрээнд гарсан зөвлөмж, боловсруулсан баримт бичгийг хүлээн авч хэрэгжүүлснээр төрийн байгууллагын үйлчилгээ, ил тод, шударга байдлын түвшин сайжирсан байна.*

Хүргүүлсэн зөвлөмж	Биелэлт
Орон нутгийн төрийн байгууллагын бүх шатны албан хаагчид удирдах байгууллагын өмнө үйл ажиллагаагаа тайлагнахаас гадна иргэдэд тодорхой хугацаанд, хуваарийн дагуу тайлганадаг байх. Энэ тухай журам боловсруулж, нийтэд мэдээлэх.	Удирдах албан тушаалтны ажлаа тайлагнах байдал дунджаар 12%-иар, цаг тухай бүртээ тайлагнасан нь 11%-иар тус тус өссөн байна.
Албан хаагчдын ажил үүргийн хуваарь, ёс зүйн дүрмийг мэдээллийн самбар, вэб сайтанд байрлуулах.	Албан хаагчийн ёс зүйн дүрэм мэдээллийн самбарт байрших нь 31-47% болж өссөн. Иргэд төрийн албан хаагчын ёс зүйн дүрмийг үзэж, танилцах (41-53%) нь нэмэгдсэн баана.
Төлбөрт үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээг нэг бүрчлэн жагсаан бичиж, мэдээлэл түгээх сувгуудаар цацах.	Төлбөр хураамжтай үйлчилгээний үнэ, хэмжээ мэдээллийн самбарт байрших нь 25-32% болж өссөн байна.
Сумын иргэдийн гар утасны дугаарыг байнга шинэчилж байх.	Суурь судалгаагаар иргэдийн 59% нь гар утас байнга ашигладаг, 29 хувь нь мсж үйлчилгээг байнга ашигладаг байсан. Төгсгөлийн судалгаагаар 20 хувь нь миний гар утсанд сумын захиргаанаас мэдээлэл ирж байсан гэж хариулсан байна. Энэ нь сумын иргэдийн гар утасны дугаарын нэгдсэн сантай болсныг харуулж байна.

Төслийн эхэнд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд “Албан хаагчид ажлын байран дээрээ байдаггүй” (19%) гэсэн шалтгаан хамгийн өндөр хувийг эзэлж байсан бол төгсгөлийн судалгаагаар “Хүндрэл бэрхшээл гараагүй” (21%) гэсэн хариулт хамгийн олон болжээ. Мөн иргэдэд нээлттэй, ойр ажилладаг төрийн албан хаагчдыг жагсаахад Засаг дарга болон ЗДТГ-ын дарга нар нэг, нэг байраар урагшилсан байна.


Бид ил тод, шударга байдлын шалгуур үзүүлэлт боловсруулан, төрийн байгууллагын ил тод, шударга байдлын түвшин бүрэн хангагдсан гэдгийг 100% байна гэж үзсэн. Төрийн байгууллагын ил тод байдлын түвшин 8,2%-иар нэмэгдэж, 50,2%, шударга байдал 2,4%-иар нэмэгдэж, 53,4% болсон байна. Энэ нь ил тод, шударга байдал бүрэн хангагдахад зарим нэг зүйлийг зайлшгүй хийх шаардлагатай байна гэсэн утгыг илтгэнэ.

- *Иргэдийн ухамсар дээшилж, идэвхи оролцоо сайжирсан байна.*

Сумын хөгжил “Засаг даргаас хамаарна” гэж ихэнх нь үзэж байгаа ч “Надаас хамаарна” гэсэн хариулт 5-6,5 % болж өссөн нь орон нутгийн хөгжил хувь хүн надаас шалтгаалдаг гэсэн ойлголт сайжирчээ.

Төслийн эхэнд нийт судалгаанд оролцогчдын 75 хувь нь сумын ИТХ-д оролцож байгаагүй харин оролцсон иргэдийн 5 хувь нь хурлаас гарсан шийдвэрт өөрийн нь санал тусгагдсан гэдгийг мэдэж байсан. Төслийн төгсгөлд багийн ИНХ болон сумын ИТХ-д оролцож байсан, санал бодлоо хэлж байсан, хурлаас гарсан шийдвэрт өөрийнх нь санал тусгагдсан тухай мэдэж байгаа иргэдийн тоо 7-12 хувиар нэмэгдсэн. Мөн иргэдийн санал хурлын шийдвэрт тусгагдах байдал хоёр дахин нэмэгдсэн байна.

Иргэдийн идэвхи оролцоо (Багийн ИНХ, Сумын ИТХ)



- *Иргэдийн хүсэлтэнд хариу өгөх чадвахи сайжирсан байна.*


Суурь судалгаанд оролцогчдын 10% нь өргөдөл гомдол гаргаж байснаас 37% шийдвэрлүүлж чадсан бол төгсгөлийн судалгаанд оролцогчдын 20% нь өргөдөл гомдол гаргаж үүнээс 81% нь шийдвэрлүүлж чадсан. Танил талаараа дамжуулж төрийн үйлчилгээ авах нь багасан (22-17%), төрийн албан хаагчдад өгөх үнэлгээ сайжирсан (42-55%) байна.

Өргөдөл, гомдолоо шийдвэрлүүлж чадаагүй гэх иргэдийн 51 хувь нь өргөдөл, гомдол гаргаад хагас жил хүртэлх, 29 хувь нь 6 сараас 1 жил хүртэлх, 20 хувь нь 1 жилээс дээш хугацаа өнгөрч байсан бол төгсгөлийн судалгаагаар шийдвэрлүүлж чадаагүй иргэд өргөдөл, гомдол гаргаад 10 хоногоос 5 сарын хугацаа өнгөрч байна гэсэн нь иргэдэд түргэн шуурхай хариу өгдөг болсон байна.

- *Мэдээлэл түгээх шинэ сувгаас иргэд мэдээлэл авч байна.*

Төслийн индикатор 2.2-т орон нутгийн иргэдийн 60% нь мэдээллийн самбар болон цахим хуудсаар, 80 хувь нь мсж-ээр мэдээлэл хүлээн авна гэсэн үр дүн хүлээсэн. Судалгаанд Төгсгөлийн судалгаанаас харахад цахим хуудас болон мэдээллийн самбараас мэдээлэл авсан иргэд 86% байгаа нь, харин мсж-ээр мэдээлэл авсан иргэд тоог харахад хүлээн үр дүнтээ хангалттай хүрч чадсангүй.


Мэдээлэл авч байсан, хүлээн авсан.



Суурь судалгаатай харьцуулахад мэдээлэл түгээх хэрэгслүүд болох гар утас, телевиз, сонин, хэвлэл, Fm, радио, интернэтийг ашиглах давтамж нэмэгдсэн, тэр дундаа Fm радиогийн хэрэглээ хамгийн сайн өсөлттэй байв.

- *Мэдээлэл түгээх шинэ суваг болох цахим хуудсаас мэдээлэл авах байдал ихссэн байна.*

Төрөл бүрийн мэдээлэл авдаг мэдээллийн их сурвалжийн хувьд төслийн эхэнд 38% нь амаар, 62% нь медиагаас авч байсан бол төгсгөлд 28% нь амаар, 72% нь медиагаас мэдээлэл авч байна. Медиаг дотор нь задалж үзвэл FM радио, интернээс мэдээлэл авах байдал нэмэгдсэн байна.



Орон нутгийн тухай мэдээллийн эх сурвалжийн хувьд иргэд амаар мэдээлэл авах нь багаж медиа, төрийн албан хаагч, захиргааны мэдээллийн самбараас мэдээлэл авах нь ихссэн байна.

